

**“ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН НЭР ТОМЬЁОНЫ СТАНДАРТ - ТЕХНИК”
СТАНДАРТЫГ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР**

<p>Боловсруулах үндэслэл, хэрэгцээ, шаардлага</p>	<p>Техник технологи хурдацтай хөгжихийн хирээр мэдээлэл хүлээн авах төрөл, хэлбэр улам өсөн нэмэгдэж байгаа мэдээ, мэдээллийн их урсгалын өнөө үед телевиз нь мэдээлэл авах үндсэн хэрэгсэл төдийгүй төрөл бүрийн хөтөлбөрөөр дамжуулан танин мэдэхүй, боловсрол, соёл, урлагийг хүргэх гэр бүлийн дундын хэрэгсэл болсон хэвээр байна.</p> <p>Манай улсад өнөөдрийн байдлаар 168 телевиз,суваг, 82 ФМ радио, 60 гаруй олон сувгийн дамжуулах үйлчилгээ эрхлэгчид тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж байгаа хэдий ч Өргөн нэвтрүүлгийн хууль хараахан батлагдаагүй, хууль эрхзүй, зохицуулалтын орчин бүрэн бүрдээгүй байна. Технологийн хувьсал хөгжилтэй уялдан өргөн нэвтрүүлгийн салбар өргөжин тэлж, төрөл бүрийн үйлчилгээ шинэ тутам гарч байгаа өнөө үед өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэхтэй холбоотой салбарын нэр томьёо тодорхойлолт нь хууль эрхзүйн баримт бичгүүдэд тусаагүй, зарим нэр томьёо, тодорхойлолт тодорхой бус, янз бүрийн үг хэллэгээр хэрэглэж байгаа нь салбарын төдийгүй бусад салбаруудад гарч байгаа хууль эрхзүй, зохицуулалтын баримт бичгүүд дэх өргөн нэвтрүүлэгтэй холбоотой зүйл заалтуудад нэр томьёог янз бүрээр тусгах, үл ойлголцол үүсэх байдалд хүрч байна.</p> <p>Тус хорооны 2015 оны 15-р тогтоолоор шинэчлэн баталсан “Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, нөхцөл шаардлага”-д нэр томьёоны тайлбарыг тусгаж өгсөн хэдий ч энэ нь зөвхөн тухайн нөхцөл шаардлагаар зохицуулагдах харилцаатай холбоотой нэр томьёо, үг хэллэгээр хязгаарлагдаж байгаа юм. Иймд өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх, өргөн нэвтрүүлгийн хөтөлбөр бэлтгэн дамжуулахтай холбоотой бодлого, зохицуулалтын орчныг илүү сайжруулах, тавигдах нөхцөл шаардлагыг эргэн харах шаардлага тулгарч байгаа бөгөөд үүнтэй уялдан холбогдох нэр томьёог олон улсад хэрэглэгддэг нэр томьёонд нийцүүлж, нэгдсэн стандарт болгон гаргах, төрийн болон төрийн бус байгууллагууд, өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчид, судлаачид зэрэг холбогдох бүх талуудад нэр томьёоны нэгдсэн ойлголттой болж хэвших нь зүйтэй байна.</p> <p>Уг стандартыг гаргаснаар харилцаа холбоо, өргөн нэвтрүүлгийн болон бусад холбогдох салбаруудад өргөн нэвтрүүлгийн чиглэлээр гарч байгаа хууль эрхзүйн баримт бичиг, төр засгийн бодлого, хөтөлбөрүүдэд нэгдсэн нэг нэр томьёо ашиглах үндэс суурь тавигдах юм.</p> <p>Түүнчлэн мэдээ, мэдээллийн эрин үед салбарын холбогдох нэр томьёоны стандарт гарч, нэгдсэн нэг ойлголтоор хэрэглэж, нэр томьёо тогтвортой байх нь мэдээ, мэдээллийг түргэн шуурхай олж авахад ач холбогдолтой.</p>
<p>Стандартын хамрах хүрээ /юуг тодорхойлох/</p>	<p>Энэхүү стандартаар Радио, телевизийн өргөн нэвтрүүлгийг бэлтгэх, дамжуулах, дахин дамжуулах, хүлээн авахтай холбоотой бүхий л шатанд хэрэглэгдэх техник, тоног төхөөрөмж, технологитой холбоотой нэр томьёог тодорхойлно.</p> <ul style="list-style-type: none"> - өргөн нэвтрүүлгийг бэлтгэх, дамжуулах, дахин дамжуулах, хүлээн авах бүх орчин, технологи, платформыг хамруулах, - Олон улсад хэрэглэгддэг тогтсон /Англи хэл дээрх/ нэр томьёо, нэршлийн хамт тусгах, - Аливаа хууль эрхзүйн орчин, технологийн өөрчлөлт шинэчлэл, зах зээлийн хувьсал хөгжлөөс аль болох үл хамаарсан тогтвортой байхаар тодорхойлох
<p>Стандартыг мөрдөх газрууд</p>	<p>Харилцаа холбоо, өргөн нэвтрүүлгийн салбарын холбогдох бүх талууд үйл ажиллагаандаа уг стандартаар тодорхойлсон нэр томьёог ашиглах, Төрийн бодлого боловсруулагчид, эрдэмтэн, судлаачид, холбогдох мэргэжлтэн, зөвлөхүүд өргөн нэвтрүүлэгтэй холбоотой хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, стандарт, зөвлөмж зэрэг баримт бичиг боловсруулахдаа ашиглах,</p>

Ууялдуулах
баримт бичиг,
стандарт

1. Монгол улсын холбогдох хууль эрхзүйн орчин,
2. Өргөн нэвтрүүлгийн хөтөлбөр, агуулгатай холбоотой зүйл заалтуудыг тусгасан Монгол улсын холбогдох хуулийн заалтууд,
3. Харилцаа холбооны салбарын хууль эрхзүй, хөгжлийн бодлого, зохицуулалтын үйл ажиллагааг тодорхойлсон баримт бичгүүд,
4. Шинжлэх ухаан технологийн их сургууль, Мэдээлэл, холбоо технологийн сургуулиас гаргасан Мэдээлэл, харилцаа холбооны технологийн Англи нэр томъёоны тайлбар
5. Харилцаа холбооны салбарын Олон улсын болон үндэсний стандарт, зөвлөмжүүд,
6. Өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын хувьд тэргүүн туршлага бүхий улс орнуудын Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, техникийн стандарт, шаардлага, тэдгээрийн харилцааг зохицуулсан зохицуулалтын баримт бичгүүдэд туссан нэр томъёо, үг хэллэг. Тухайлбал, Австрали, Англи, Канад, ёс заншил ойролцоо Азийн улс орнууд, Өмнөд Солонгос, Сингапур гм
7. Бусад холбогдох баримт бичгүүд